



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2013 оны 08 сарын 16 өдөр

Дугаар 142

Мандалговь

Хөрөнгө худалдах тухай.

“Төрийн болон орон нутгийн өмчийн” тухай хуулийн 77 дугаар зүйлийн 3 Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журмын 3 дугаар зүйлийн 3.1 “в”, 3.2.6 “а”, 4 дүгээр зүйлийн 4.1 дэхь заалтуудыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Говь-угтаал сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 3000,0 мянган төгрөгийн балансын анхны өртөгтэй, 583,3 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, Дуа 36-00 улсын дугаартай Мазда маркийн автомашиныг Мэргэжлийн хяналтын улсын байцаагч, Сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн худалдах үнийн доод хязгаарыг 500000 /таван зуун мянган/ төгрөгөөр тогтоож дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Дуудлага худалдаагаар худалдагдсан автомашиныг зохих журмын дагуу бүртгэлээс хасахыг Говь-угтаал сумын ЗДТГ-ын дарга /Г.Эрдэнэцэцэг/-д даалгасугай.

3. Орон нутагт дуудлага худалдааг хууль, дүрэм журмын дагуу явуулж, орсон орлогыг орон нутгийн 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн алба /П.Очирбат/-нд үүрэг болгосугай.

ДАРГА

С.БУДЖАВ

